



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 4/145

Хужирт сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай  
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Өвөрхангай аймгийн Засаг даргын 2021 оны “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А\490 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч тархсан 1, 6 дугаар багийн 6250 га бэлчээрт энгийн механик биологийн аргаар тэмцэх ажлын 2021 оны 10 дугаар сарын 25-29-ны хооронд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.
2. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг хянах, үр дүнг тооцох ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар байгуулсугай.
3. Мэрэгчтэй тэмцэх ажилд малчид, малчны бүлэг, хоршооны гишүүдийг хамруулах, тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх, богино хугацаанд бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсэг, ахлагч Б.Дэмбэрэлд үүрэг болгосугай.
4. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Бямбасүрэн, ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг заавар журмын дагуу гаргаж 2021 оны 11 дүгээр сарын 01-ны дотор Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч Б.Дэмбэрэл нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Т.БАЯРМОНХ

620100289

Сумын Засаг даргын 20<sup>24</sup> оны  
10. дугаар сарын 20<sup>24</sup>-ны өдрийн 17 дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл-Засаг даргын орлогч  
Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбат-Бэлчээр, газар тариалангийн  
асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Ц.Нямдорж-Газрын даамал  
С.Самдан-Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн  
Б.Доржсэмбэ-Хүнс, жижиг, дунд үйлдвэр хоршооны асуудал  
хариуцсан мэргэжилтэн  
Б.Бямбасүрэн-Байгаль орчны хяналтын Улсын байцаагч  
Ч.Сонинбаяр-Байгаль хамгаалагч  
Б.Дуламжав-Байгаль хамгаалагч  
Г.Оюунмандах-Нягтлан бодогч  
Б.Пагамдулам-Өвөрмодот 1 дүгээр багийн Засаг дарга  
Ц.Амгалан-Дулаан 6 дугаар багийн Засаг дарга

-оо-